**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 21 өдөр Дугаар А/293 Хэрлэн сум

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
томилж,төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалт, Хэнтий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 5 дугаар хуралдааны 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Ирээдүйн эзэд” Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025, 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрт шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын “Ирээдүйн эзэд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, хөтөлбөрийн хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж, тайлагнахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Түмэнжаргал)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Д.АЮУРБУНЬ

D:\My Documents\ Захирамж-2025

23101C906

Аймгийн Засаг даргын 2025 оны
05 дугаар сарын 21 –ний өдрийн
А/293 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

# "ИРЭЭДҮЙН ЭЗЭД" ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн дарга: | Б.Өнөрцолмон | -Аймгийн Засаг даргын орлогч |
| Ажлын хэсгийн дэд дарга: | Б.Түмэнжаргал | Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| Нарийн бичгийн дарга: | Х.Уртнасан | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга |
| Гишүүд: | Ш.Жавхлан | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга |
| | А.Жаргалсайхан | Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| | Н.Үнэнбат | Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга |
| | Ц.Ганчимэг | Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтийн дарга |
| | Э.Жавхлантөгс | Цагдаагийн газрын дарга |
| | С.Мөнхцэцэг | Боловсролын газрын дарга |
| | Д.Дашнамжилмаа | Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| | Ж.Эрдэнэбат | Онцгой байдлын газрын дарга |
| | Э.Хонгорзул | Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга |
| | А.Гантөмөр | Татварын газрын дарга |
| | Т.Зулбаатар | Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| | Г.Солонго | Биеийн тамир, спортын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| | Б.Төрхүү | -Улсын бүртгэлийн хэлтсийн дарга |
| | Г.Гантөмөр | Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| | М.Дарьхүү | "Хэнтий орон сууц" ОНӨААТҮГ-ын Захирал |
| | | Сумдын Засаг дарга нар |
| | | Тосгодын Захирагч нар |

Аймгийн Засаг даргын
2025 оны 05 дугаар сарын 21 –ны
А/293 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

"ИРЭЭДҮЙН ЭЗЭД" ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 2025-2026 ОН /ТӨСӨЛ/

| № | Чиглэсэн үйл ажиллагаа | Чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 он | | 2026 он | | Хэрэгжүүлэгч байгууллага | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хүрэх түвшин үр дүнгийн үзүүлэлт | Хөрөнгө | Хүрэх түвшин үр дүнгийн үзүүлэлт | Хөрөнгө | Үндсэн | Хамтрагч | Оролцогч |
| 1 | 2 | 3 | | 4 | 5 | 6 | 7 | | | | |
| ЗОРИЛТ 1. СУДАЛГААНД СУУРИЛСАН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАМААР ГЭР БҮЛ, ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛНА | | | | | | | | | | | |
| 1 | 1.1 Гэр бүлийн харилцаанд гарч буй өөрчлөлт хандлагыг тодорхой хугацааны давтамжтайгаар судалж үр дүнг бодлого, үйл ажиллагаанд тусгаж ажиллах | 1.1.1 Өрх гэр бүлийн тулгамдсан асуудлыг тодорхойлох суурь судалгаа авна | Судалгаанд хамрагдсан өрхийн тоо | **** | Нийт өрхийн 10%-с суурь судалгаа авна | | **** | | ХГБХХГ | Сумдын ЗД | Иргэд |
| | | 1.1.2 Судалгааны үр дүнг нэгтгэж аймгийн ИТХ-д танилцуулна | Судалгааны үр дүнг аймгийн ИТХ-д танилцуулсан эсэх, төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлсэн заалтын тоо | **** | Судалгааны үр дүнг аймгийн ИТХ-д танилцуулж, судалгааны үр дүнгээр гарсан 3-аас доошгүй заалтыг хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ | | Судалгааны үр дүнгээр гарсан 4-өөс доошгүй заалтыг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | Аймгийн ИТХ | Хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагууд |
| | 1.2 Мэргэжлийн байгууллагатай харилцан туршлага солилцох, гэр бүл, хүүхдийн хөгжил хамгааллын чиглэлээр судалгаа, ном гарын авлага боловсруулах олон нийтийн хүртээл болгох | 1.2.1 Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын чиглэлээр судалгаа, ном гарын авлага боловсруулж олон нийтийн хүртээл болгоно | Шинээр боловсруулсан ном, гарын авлагын тоо | Эрдэм, шинжилгээний бага хурлын эмхэтгэл 2024, Хүүхдийн аж байдал 2021, 2022 эмхэтгэл | **** | | 1-2 төрлийн ном, гарын авлага гаргаж нийтийн хүртээл болгоно | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | ТББ | Иргэд |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1.3 Хүүхэд, гэр бүлийн статистик мэдээллийн үнэн зөв байдлыг хангахад салбар дундын уялдааг хангаж, мэдээллийн сангийн чанарыг сайжруулах, дүн шинжилгээ хийх, гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх | 1.3.1 Хүүхэд, гэр бүлийн статистик мэдээнд дүн шинжилгээ хийж, гарсан дүгнэлт зөвлөмжийн хэрэгжилийг хангана | Дүн шинжилгээ хийсэн тоо, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | Статистик мэдээг хагас жил, жилийн эцсийн байдлаар ХТЗ-д танилцуулсан. Дүн шинжилгээ хийгдээгүй | Статистик мэдээнд 1 удаа дүн шинжилгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргана. Дүгнэлт зөвлөмжийн хэрэгжилт 80%-иас дээш байх | 0.5 сая/ут/ | Статистик мэдээнд 1 удаа дүн шинжилгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргана. Дүгнэлт зөвлөмжийн хэрэгжилт 80%-иас дээш байх | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | | ХТЗ-ийн гишүүн байгууллагууд |
| | 1.4 Хүүхэд, гэр бүлд чиглэсэн үйлчилгээний чанар хүртээмж, иргэдийн ойлголт хандлагыг тодорхойлох судалгааг тодорхой давтамжтай зохион байгуулах | 1.4.1 Хүүхэд, гэр бүлд чиглэсэн үйлчилгээний чанар хүртээмжийн судалгаа авч, үр дүнг бодлого, үйл ажиллагаанд тусгаж ажиллана | Гэр бүл, хүүхдийн асуудлаар хийгдсэн суурь судалгааны тоо, судалгааны үр дүнг тусгаж хэрэгжүүлсэн баримт бичгийн тоо | Энэ чиглэлийн судалгаа хийгдээгүй | Түүвэр судалгааг 1 удаа хийж, үр дүнг баримт бичигт тусгаж хэрэгжүүлнэ | 8.0 сая /ут/ | **** | | ХГБХХГ | ТББ | Иргэд |
| **ЗОРИЛТ 2. ГЭР БҮЛ, ХҮҮХДИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ЗАМААР ГЭР БҮЛ, ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ НИЙГМИЙН ОРЧИН БҮРДҮҮЛНЭ** | | | | | | | | | | | | |
| 2 | 2.1. Хүүхэд, гэр бүлийн чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийг тухайлан бэлтгэх | 2.1.1 Хүүхдийн өмнө үүрэг хүлээсэн бүх шатны байгууллага, хуулийн этгээд, аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Хамтарсан баг, Эцэг эхийн зөвлөл, Хүүхдийн элч, Олон нийтийн байцаагч, Нийгмийн ажилтан, сумдын асаг дарга нарыг арга зүйгээр хангана | Хүүхэд, гэр бүлийн чиглэлээр мэргэшүүлэх болон чадавхжуулах сургалтад хамрагдсан үүрэг хүлээгчдийн хувь | 6 удаагийн сургалт, 1 арга хэмжээнд давхардсан тоогоор 456 үүрэг хүлээгч буюу нийт үүрэг хүлээгчдийн 66%-ийг хамруулж чадавхжуулсан | 7-оос доошгүй сургалт зохион байгуулж үүрэг хүлээгчдийн 70-аас дээш хувийг хамруулна | 10.0 сая/онт/ | 8-аас доошгүй сургалт зохион байгуулж үүрэг хүлээгчдийн 80-аас дээш хувийг хамруулна | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | Сумдын ЗД | Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчид |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.2 Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, хэлтэс, бусад байгууллагын мэргэжилтнүүдийг мэргэшүүлэн сургах, чиг үүргийг жигд тодорхой болгох | 2.2.1 Одоо ажиллаж байгаа албан хаагчдыг хүүхэд, гэр бүлийн чиглэлээр мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх нөхцөл бүрдүүлэх | Мэргэжил дээшлүүлсэн албан хаагчдын тоо | 2 албан хаагч Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтад хамрагдсан | 10 албан хаагчийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулна | 2.5 сая/ут/ | 10 албан хаагчийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулна | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | АЗДТГ-ын НБХ | Салбарын албан хаагчид |
| | | 2.2.2 Хүүхэд, гэр бүлийн чиглэлээр суралцаж байгаа оюутан залуусын дунд тэтгэлэгт хөтөлбөр зарлан хэрэгжүүлнэ | Тэтгэлэгт хамрагдсан оюутны тоо | **** | **** | | 1-2 оюутан хамруулна | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | АЗДТГ-ын НБХ | Оюутнууд |
| | 2.3 Гэр бүл, хүүхдэд үйлчилгээ үзүүлэх асуудлаар бусад орны болон аймгийн мэргэжлийн байгууллага, хүмүүстэй харилцан туршлага солилцож, үйл ажиллагааны хүрээгээ өргөжүүлэх, хамтрах | 2.3.1 Хүүхэд, гэр бүлийн чиглэлээр ажилладаг албан хаагчдыг өөр аймаг, бусад орны сайн туршлага судлах, солилцох нөхцөл боломжийг бүрдүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлнэ | Туршлага судалсан албан хаагчдын тоо | 1 албан хаагч БНСУ-д 2024 онд туршлага судалсан | **** | | 2-оос доошгүй албан хаагчид туршлага судлах, нөхцөл бүрдүүлнэ | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | АЗДТГ-ын НБХ | Салбарын албан хаагчид |
| | 2.4 Олон улсын болон хөгжлийн байгууллага, агентлагийн гэр бүл, хүүхдийн хөгжилд зориулж байгаа дэмжлэг, үйл ажиллагааг хөтөлбөртэй уялдуулах | 2.4.1 Ирээдүйн ээзд хөтөлбөрийн зарим арга хэмжээг олон улсын болон хөгжлийн байгууллага, ТББ-тай хамтран хэрэгжүүлнэ | ОУ-ын болон ТББ-тай хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | 3 ТББ-тай хамтран ажилласан. | 3-аас доошгүй арга хэмжээг хамтран хэрэгжүүлнэ | | 5-аас доошгүй арга хэмжээг хамтран хэрэгжүүлнэ | | ХГБХХГ | АЗДТГ Сумдын ЗД, ТББ | Иргэд |
| | 2.5 Гэр бүлийн өдөр, гэр бүл, хүүхдийн амралт, чөлөөт цагийн газруудыг бий болгох, гэр бүлд чиглэсэн дэмжлэг үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжийг урамшуулах | 2.5.1 Гэр бүл, хүүхдийн амралт чөлөөт цаг өнгөрүүлэх орчин бий болгож, засаж сайжруулна | Гэр бүл, хүүхдийн амралт чөлөөт цагийн орчин бий болгож, засаж сайжруулсан тоо | **** | 3-аас дээш амралт, чөлөөт цаг өнгөрүүлэх орчин бий болгож, засаж сайжруулна | | 5-аас дээш амралт, чөлөөт цаг өнгөрүүлэх орчин бий болгож, засаж сайжруулна | | ХГБХХГ | Сумдын ЗД | Иргэд |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.6 Орон нутгийн Хамтарсан баг, бүх шатны Засаг даргын дэргэдэх Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, гишүүдийг хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр сургах | 2.6.1 Ирээдүйн ээзд хөтөлбөрийн зарим арга хэмжээг олон улсын болон хөгжлийн байгууллага, ТББ-тай хамтран хэрэгжүүлнэ | Хамтран ажилласан ТББ-ын тоо | 3 ТББ-тай хамтран ажилласан. | 3-аас доошгүй ТББ-тай хамтран ажиллана | | 5-аас доошгүй ТББ-тай хамтран ажиллана | | ХГБХХГ | АЗДТГ Сумдын ЗД, ТББ | |
| | **ЗОРИЛТ 3. ГЭР БҮЛД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨГӨӨ, СУРГАЛТЫН АЖЛЫГ ӨРГӨЖҮҮЛЭХ ЗАМААР ГЭР БҮЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ, ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАНА** | | | | | | | | | | |
| 3 | 3.1 Зорилтот бүлгүүдэд (Залуу, дунд, ахмад насны гэр бүл, өсвөр үе, бусад) зориулсан гэр бүлийн боловсролын сургалтын агуулга, арга зүйг боловсруулж хэрэгжүүлэх | 3.1.1 Залуу гэр бүлд зориулсан арга зүй боловсруулж, хэрэгжүүлнэ | Гэрлэлтийн гэрчилгээ авахын өмнөх арга зүйн сургалтад хамрагдсан хосын хувь | **** | Шинэ боловсруулсан арга зүйг залуу хос, шинэ гэрлэгсдийн 20-иос дээш хувьд хэрэгжүүлнэ | 8.0 сая/ут/ | Шинэ боловсруулсан арга зүйг залуу хос, шинэ гэрлэгсдийн 30-аас дээш хувьд хэрэгжүүлнэ | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | Улсын бүртгэлийн хэлтэс | Иргэд |
| | 3.2 Гэр бүлийн боловсрол олгох сургалт, мэдээлэл хүргэх үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлэх | 3.2.1 Гэр бүлийн цогц төвөөр дамжуулан урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн олон талт ажил зохион байгуулна | Сургалт, нөлөөллийн ажлын тоо, хамрагдсан өрхийн хувь | Урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажил 5 удаа зохион байгуулж 1362 өрх буюу 30 хувьд | Гэр бүлийн боловсрол олгох сургалт 8 удаа, нөлөөллийн ажил 3 удаа зохион байгуулж бүсийн нийт өрхийн 30%-д урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлнэ | 5.0 сая/онт/ | Гэр бүлийн боловсрол олгох сургалт 8 удаа, нөлөөллийн ажил 3 удаа зохион байгуулж бүсийн нийт өрхийн 35%-д урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлнэ | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | Сумдын ЗД | Иргэд |
| | | 3.2.2 Цогц төвөөр дамжуулан үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд тулгуурлан шаардлагатай үйлчилгээг хүргэнэ. | Үйлчилгээ авсан эрсдэлт өрхийн хувь | Эрсдэлт бүлгийн 11 өрх буюу 3 хувьд цогц үйлчилгээ үзүүлсэн. | Эрсдэлт өрхийн 5%-д цогц үйлчилгээ үзүүлнэ | 5.0 сая /онт/ | Эрсдэлт өрхийн 5%-д цогц үйлчилгээ үзүүлнэ | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | Сумдын ЗД | Иргэд |
| | 3.3 Нийгэмд эерэг нөлөө үзүүлж байгаа гэр бүлүүдийг урамшуулах, гэр | 3.3.1 Нийгэмд эерэг нөлөө үзүүлж байгаа гэр бүлийг | Алдаршуулсан гэр бүлийн тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ | **** | 5 гэр бүлийг шалгаруулж, алдаршуулна. | 3.0 сая /ут/ | 5 гэр бүлийг шалгаруулж, алдаршуулна | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | Сумдын ЗД | Иргэд |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх нөлөөллийн олон талт үйл ажиллагааг зохион байгуулах | алдаршуулж урамшуулна | | | | | | | | | |
| | 3.4 Бүсийн "Гэр бүлийн хөгжлийн төв" байгуулах | 3.4.1 Гэр бүлийн хөгжлийн төв байгуулна | Шинээр бий болсон гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийн тоо | **** | 2 суманд байгуулна | 60.0 сая /онт/ | 2 суманд байгуулна | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | Сумдын ЗД | Иргэд |
| | **ЗОРИЛТ 4. ЭЦЭГ, ЭХИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗАМААР ГЭР БҮЛ ДЭХ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫГ БЭХЖҮҮЛНЭ** | | | | | | | | | | |
| 4 | 4.1 Эцэг, эхийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, хүүхдийг сурч хөгжихөд дэмжлэг үзүүлэх гэр бүлийн орчныг сайжруулахад чиглэсэн эцэг, эхийн боловсролын сургалтыг эрчимжүүлэх | 4.1.1 Сумын нутаг дэвсгэр, албан байгууллага, аж ахуй нэгжид орчны эрсдэлийн үнэлгээ хийж, илрүүлсэн эрсдэлийг бууруулах ажлыг зохион байгуулна | Эрсдэлийн үнэлгээ хийсэн сумдын хувь, эрсдэл бууруулсан хувь | 2023 сумдын 76 хувьд үнэлгээ хийж орчны эрсдлийн үнэлгээг хийж эрсдэл 12.2 хувиар буурсан | Нийт сумдын 80%-д орчны эрсдэлийн үнэлгээ хийж, илэрсэн зөрчлийн 50%-ийг бууруулна | | Нийт сумдын 80%-д орчны эрсдэлийн үнэлгээ хийж, илэрсэн зөрчлийн 60%-ийг бууруулна | | ХГБХХГ | Сумдын ЗД, Байгууллага, ААН | Иргэд |
| | 4.2 Өрхийн аюулгүй, эрсдэлгүй орчныг бий болгоход нөлөөлөх, зөвлөмжийг түгээх | 4.2.1 "Хамтдаа шалгая, хамгаалъя" аян өрнүүлэх | Аянд хамрагдсан өрхийн хувь | 2023 онд "Хамтдаа шалгая, хамгаалъя" аянд 2557 өрх хамруулсан | "Хамтдаа шалгая, хамгаалъя" аянд нийт өрхийн 10%-г хамруулна | | "Хамтдаа шалгая, хамгаалъя" аянд нийт өрхийн 15%-г | | ХГБХХГ | Сумдын ЗД, Байгууллага, ААН | Иргэд |
| | 4.3 Хүүхдийг чанартай хоол хүнс, шаардлагатай амин дэмээр дутаахгүй байх, хүүхдийн бие махбод, сэтгэл зүйн хэрэгцээг хангах нөхцөлийг бүрдүүлэх уриалгыг түгээх | 4.3.1 "Чанартай хоол хүнс, шаардлагатай амин дэм" аян өрнүүлнэ. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан иргэдийн хувь | **** | **** | | 3-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулж нийт иргэдийн 10%-г хамруулна | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | БГ, Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл, ЭМГ | Иргэд |
| | 4.4 Эцэг, эх, асран хамгаалагч, олон нийтэд хүүхдийг асрах, зэрэг аргаар хүмүүжүүлэх мэдлэг, хандлага | 4.4.1Хүүхэд хүмүүжлийн зэрэг арга сургалт зохион байгуулж, хамрагдалтыг нэмэгдүүлнэ | Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан өрхийн хувь | Хүүхэд хүмүүжлийн зэрэг арга сургалтад 2883 өрх хамрагдсан | Нийт өрхийн 10-аас дээш хувийг хамруулна | 3.0 сая /ут/ | Нийт өрхийн 20-иос дээш хувийг хамруулна | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл | Иргэд |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвшүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдийг сургалтад хамруулах | 4.4.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдийг сэтгэл зүйн зөвлөгөө, сургалтад хамруулна | Сургалтын тоо, бүлгийн зөвлөгөөний тоо | 5 удаагийн бүлгийн сургалтад 32 хүн хамруулсан | 2 удаагийн сургалт, 2 удаагийн сэтгэл зүйн бүлгийн зөвлөгөө зохион байгуулна | 2.0 сая /ут/ | 2 удаагийн сургалт, 2 удаагийн сэтгэл зүйн бүлгийн зөвлөгөө зохион байгуулна | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | ХХҮГ | ХБХ-тэй эцэг эхчүүд |
| | 4.5 Хүүхдийг ахуйн болон зам тээврийн осол, гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар эцэг, эх, асран хамгаалагч нарын хариуцлагыг нэмэгдүүлэх сурталчилгааны ажлыг өрнүүлж, санамж, сэрэмжлүүлэг түгээх | 4.5.1 Хүүхдийг ахуйн болон зам тээврийн осол, гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулна | Хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн арга хэмжээний тоо, хамрагдсан иргэдийн хувь | Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх "Замын хөдөлгөөний цагаан толгой" тэмцээн зохион байгуулж 100 хүүхэд хамруулсан | 3-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулж нийт иргэдийн 10%-иас доошгүйг хамруулна | 3.0 сая /ут/ | 5-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулж нийт иргэдийн 15%-иас доошгүйг хамруулна | Батлагдсан төсвийн хүрээнд | ЭМГ | ЦГ, Сумдын ЗД | Иргэд |
| | 4.6 Үр хүүхдээ тэвчишгүй, хүнд хөдөлмөр эрхлүүлэхгүй байх, гэмт хэрэг зөрчлийн оролцогч болохоос сэргийлэх, нийгмийн оролцоот иргэн болгон төлөвшүүлэхэд шаардлагатай ур чадварыг эцэг эхчүүдэд олгох | 4.6.1 "Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт", 13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын төрөл, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл"-ийг аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчлан таниулах, хүүхдийг тэвчишгүй хөдөлмөр, хөдөлмөрийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулна | Хяналт шалгалтын тоо, хамруулсан байгууллага, ахуй нэгжийн тоо | Насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг илрүүлэх хяналт шалгалт 3-г зохион байгуулж, 131 аж ахуй нэгжид хүрч ажиллан 3 зөрчил илрүүлсэн | Хяналт шалгалтыг 2-оос доошгүй зохион байгуулж, урьдчилан сэргийлэх ажилд 100-аас доошгүй байгууллага, аж ахуй нэгж хамруулна | 2.0 сая /ут/ | Хяналт шалгалт 2 удаа зохион байгуулж, урьдчилан сэргийлэх ажилд 120-иос доошгүй байгууллага, аж ахуй нэгж хамруулна | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | Сумдын ЗД, Байгууллага, ААН | Иргэд |
| | **ЗОРИЛТ 5. ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХИЙГ ХАНГАХАД САЛБАР ДУНДЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛНЭ.** | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | 5.1 Гэр бүл, хүүхдийн эрх ашигтай холбоотой үндэсний бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг салбар бүрд сайжруулах, салбар бүрийн хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх | 5.1.1 ХШҮ хийж, дүгнэлт зөвлөмж хүргүүлж хэрэгжилтийг хангана | ХШҮ хийсэн сумдын тоо | ХШҮ хийгдсэн, дүн ХТЗ-д танилцуулагддаггүй | 5-аас доошгүй сумдын Хамтарсан баг, Хүүхдийн төлөө зөвлөл, Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл, хүүхдийн элчийн үйл ажиллагаанд ХШҮ-хийж, дүгнэлт зөвлөмж хүргүүлнэ | 4.0 сая /ут/ | 10-аас доошгүй сумдын Хамтарсан баг, Хүүхдийн төлөө зөвлөл, Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл, хүүхдийн элчийн үйл ажиллагаанд ХШҮ-хийж, дүгнэлт зөвлөмж хүргүүлнэ | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | Сумдын ЗД | |
| | 5.2 Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуулийг тухайлан сурталчлан таниулах | 5.2.1 Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуулийг иргэдэд сурталчлан таниулах арга хэмжээ зохион байгуулна | Зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдсан хүний тоо | Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуулийг 2247 иргэнд сурталчилсан | 3-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулж 500-аас доошгүй иргэн хамруулна | 3.0 сая /ут/ | 3-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулж 1000-аас доошгүй иргэн хамруулна | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | Сумдын ЗД | Иргэд |
| | 5.3 Бүх шатны байгууллагын эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж хүүхэд хамгааллын бодлогыг /хүүхэд, гэр бүлд ээлтэй ажлын байрны бодлого/ хэрэгжүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд байгууллага аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэх | 5.3.1 Бүх шатны байгууллагын эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд байгууллага аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын бодлого болон Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дахь заалтыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна | Хүүхэд хамгааллын бодлого баталж, мөрдсөн байгууллага, аж ахуй нэгжийн хувь | Нийт 192 эцэг эхийн зөвлөлийн 98.4 хувь нь хүүхэд хамгааллын бодлого баталсан. | Орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төр, хувийн хэвшлийн байгууллагын 80%-д хүүхэд хамгааллын бодлогыг мөрдүүлнэ | | Орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төр, хувийн хэвшлийн байгууллагын 90%-д хүүхэд хамгааллын бодлогыг мөрдүүлнэ | | ХГБХХГ | Сумдын Засаг дарга, Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл ААН | Иргэд |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 5.4 Хүүхэд төвтэй гэр бүлийн халуун дулаан, амар тайван харилцааг бэхжүүлэх, нийтийг хамарсан нөлөөллийн ажил, хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, хамгаалах асуудалд салбар бүрийн оролцоог нэмэгдүүлэх | 5.4.1 Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээрх бүх нийтийг хамарсан нөлөөллийн, хууль сурталчлах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг олон нийтийн оролцоо, дэмжлэгт тулгуурлан холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулж танхимаар болон цахимаар хүргэж оролцоог нэмэгдүүлэх | Орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээрх арга хэмжээ, лекц, сургалтын тоо, хамрагдсан иргэдийн хувь | Урьдчилан сэргийлэх чиглэлээр 8 үйл ажиллагаа, 2 аян, 4 нөлөөллийн ажил, 2 өдөрлөг, 4 арга хэмжээ, 7 төрлийн тэмцээн, 6 уралдаан, нийт 33 төрлийн үйл ажиллагаанд 23351 хүүхэд, 20979 насанд хүрэгчийг хамруулж, нийт хүн амын 56,2 хувьд хүрч ажилласан | 14-өөс доошгүй лекц, сургалт, арга хэмжээ зохион байгуулж, нийт хүн амын 35-аас доошгүй хувийг хамруулна | 10.0 сая/онт/ 15.0 сая /ут/ | 14-өөс доошгүй лекц, сургалт, арга хэмжээ зохион байгуулж, нийт хүн амын 45-аас доошгүй хувийг хамруулна | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | Сумдын ЗД | Иргэд |
| | 5.5 Хүүхдийг аливаа эрсдэлд өртөх, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх | 5.5.1 Эрсдэлд өртөж болзошгүй, эрсдэлд өртсөн хүүхэд, гэр бүлд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг хүргэнэ | Илрүүлэлтийн хувь, үзүүлсэн үйлчилгээний хувь 108 утасны шийдвэрлэлтийн хувь | Хүүхэд хамгаалал шаардлагатай зорилтот 840 хүүхдийн 271 хүүхдэд хувийн хэрэг нээсэн.Хүүхдийн тусламжийн 108 утсанд 81 дуудлага бүртгэгдсэн Дуудлага шийдвэрлэлт 88.8 хувь | Илрүүлэлтийг 50% нэмэгдүүлнэ, шаардлагатай хүүхдэд кейс нээж хариу үйлчилгээг 100% үзүүлж, 108 утасны шийдвэрлэлтийг 89-өөс дээш хувьд хүргэнэ | 80.0 сая /ут/ | Илрүүлэлтийг 60% нэмэгдүүлнэ, шаардлагатай хүүхдэд кейс нээж хариу үйлчилгээг 100% үзүүлж, 108 утасны шийдвэрлэлтийг 90-ээс дээш хувьд хүргэнэ | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | Сумдын ЗД | Иргэд |
| | 5.6 Хүүхэд нийгмийн бүх орчинд хүчирхийлэлтэй холбоотой эрсдэлээс хамгаалагдах нөхцөлийг бүрдүүлэх, эрсдэлд өртөөж болзошгүй, эрсдэлд өртсөн хүүхэд, гэр бүлд үзүүлэх тусламж, үйлчилгээг өргөжүүлэх | 5.6.1 Сум, орон нутгийн гэр бүлд үзүүлсэн явуулын үйлчилгээ үзүүлнэ | Хүүхэд хамгааллын бодлого баталж, мөрдсөн байгууллага, аж ахуй нэгжийн хувь | 14 сумын 2937 иргэнд явуулын үйлчилгээ үзүүлсэн | 10-аас доошгүй сумын 3000-аас дээш иргэнд явуулын үйлчилгээ үзүүлсэн байна. | 8.0 сая/онт/ | 10-аас доошгүй сумын 3000-аас дээш иргэнд явуулын үйлчилгээ үзүүлсэн байна | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | Сумдын ЗД | Иргэд |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 5.7 Гамшгийн үед хүүхдийн эрхийг хамгаалах, тэдэнд тусламж, үйлчилгээ үзүүлэх журмыг хэрэгжүүлэх, сургууль, цэцэрлэг, хүүхдийн байгууллагад гамшгаас хамгаалах дадлага, сургуулилалтыг тогтмолжуулах | 5.7.1 Гамшгийн үед хүүхдийн эрхийг хамгаалж шаардлагатай тусламж, дэмшлэг үзүүлж, гамшгийн дадлага сургуулилалтыг тогтмолжуулна | Хохирсон өрхөд үйлчилгээ үзүүлсэн хувь, дадлага сургуулилт хийсэн сургууль цэцэрлэгийн тоо | 13 сумын 130 өрхөд 11,658,992 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Зудын үед дэмжлэг туслалцаа шаардлагатай 11 сумын малчин өрхийн 44 хүүхдэд шаардлагатай 2,200,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн | Түргэвчилсэн үнэлгээнд үндэслэн хохирсон өрхөд үйлчилгээ 100 хувь үзүүлнэ, дадлага сургуулилтыг 5-аас доошгүй сургууль, цэцэрлэгт хийнэ | 10.0 сая/ут/ | Түргэвчилсэн үнэлгээнд үндэслэн хохирсон өрхөд үйлчилгээ 100 хувь үзүүлнэ, дадлага сургуулилтыг 8-аас доошгүй сургууль, цэцэрлэгт хийнэ | Батлагдсан төсвийн хүрээнд | ОБГ, ХГБХХГ | Сумдын ЗД | Иргэд |
| | 5.8 Гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, сэжигтэн, мөрдөн шалгагдаж байгаа, ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, шүүхээр шийтгэгдсэн хүүхдэд хууль зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг тогтмолжуулах | 5.8.1 Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлнэ | Хууль зүйн хорооны үйлчилгээ авсан хүүхдийн үйлчилгээ авах шаардлагатай нийт хүүхдэд эзлэх хувь | 60 хүүхдэд 142 удаагийн үйлчилгээ үзүүлсэн,12 удаагийн сургалтад бүртгэлтэй хүүхдийн 100 хувь хамрагдсан | Хорооноос үйлчилгээ авах шаардлагатай хүүхэд бүрд үйлчилгээг 100 хувь хүргэнэ | 4.0 сая/онт/ 6.0 сая /ут/ | Хорооноос үйлчилгээ авах шаардлагатай хүүхэд бүрд үйлчилгээг 100 хувь хүргэнэ | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | ХЭХЗХороок гишүүд | |
| **ЗОРИЛТ 6. ХҮҮХЭД БҮРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЖ, ХҮҮХДИЙН АВЬЯАС, ЧАДВАРЫГ НЭЭН ХӨГЖҮҮЛЭХЭД САЛБАР БҮРИЙН ОРОЛЦООГ ХАНГАНА** | | | | | | | | | | |
| | 6.1 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд төрийн болон иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, эцэг эх, олон нийтийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх | 6.1.1 Итгэл төгс нөмөр ТББ-ын "Ид шидийн орон" хүүхэд хөгжлийн төвөөр дамжуулан хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа явуулж хамрагдалтыг нэмэгдүүлэх | Ххөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн хувь | 10 төрлийн хөгжлийн үйлчилгээнд 14,353 хүүхэд хамрагдсан | Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийг 5%-иар нэмэгдүүлнэ | 150.0 сая/онт/ | Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийг 15%-иар нэмэгдүүлнэ | Батлагдсан төсвийн хүрээнд | "Ид шидийн орон" ХХХТ | ХГБХХГ | Хүүхдүүд |
| | 6.2 Хүүхдээс гарсан саналыг сонсох, шийдвэр гаргах түвшинд уламжлах, шийдвэрлүүлэх, | 6.2.1 Хүүхдийн чуулган зохион байгуулах | Чуулганд хамруулсан хүүхдийн тоо | "Хамгаалагдсан аз жаргалтай хүүхэд" хүүхдийн чуулган зохион байгуулж 300 хүүхэд хамруулсан | **** | 8.0 сая/онт/ | Хүүхдийн чуулган зохион байгуулах, 300-аас доошгүй хүүхэд хамруулна | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | Сумдын ЗД | Хүүхдүүд |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 6.2.2 Хүүхдээс гарсан саналыг шийдвэрлүүлэх | Шийдвэрлэсэн саналын хувь | 82 удаагийн уулзалт зохион байгуулж 2500 орчим хүүхдийн хүүхдийг хүлээн авч уулзаж, 200 гаруй хүүхдээс захидал хүлээн авч хүүхдээс гарсан санал санаачилгын 92 хувийг шийдвэрлэсэн | Хагас бүтэн жилээр "Хүүхдээ сонсоё" өдрийн тогтмолжуулан, ирсэн саналын 30 хувийг шийдвэрлэнэ | | Хагас бүтэн жилээр "Хүүхдээ сонсоё" өдрийн тогтмолжуулан , ирсэн саналын 35 хувийг шийдвэрлэнэ | | ХГБХХГ | Сумдын ЗД | Хүүхдүүд |
| | 6.3 Бага насны хүүхдийн хөгжлийг гэр бүлийн орчинд дэмжих чиглэлээр бий болсон сайн туршлагыг түгээн дэлгэрүүлж, эцэг эхийн чадавхыг нэмэгдүүлэхэд хэвлэл мэдээлэл, цахим сүлжээ ашиглах | 6.3.1 Бага насны хүүхдийн хөгжлийг гэр бүлийн орчинд дэмжих | Үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо | Бага насны хүүхэд насны хүүхдэд сэтгэл зүйн цогц үйлчилгээ үзүүлнэ | 50-иас доошгүй бага насны хүүхдэд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлнэ | | **** | | ХГБХХГ | Цэцэрлэгүүд | Хүүхдүүд |
| | 6.4 Хүүхдийг амьдрах ухаанд сургаж, харилцааны зөв хэвшилтэй, бусдыг хүндлэх, хариуцлагатай, итгэл даах чадвартай болгон төлөвшүүлэн хөгжүүлэх асуудалд салбар бүрийн оролцоог нэмэгдүүлэх | 6.4.1 Оролцооны байгууллагыг дэмжих, чадавхжуулах, идэвхжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж арга зүйгээр хангах | Сургалт, арга зүйгээр хангасан оролцооны байгууллагын хувь, байр танхимаар хангасан, дэмжлэг үзүүлсэн оролцооны байгууллагын тоо | 8 оролцооны байгууллагад 1417 хүүхэд хамрагдсан. Оролцооны байгууллагаас санаачлан зохион байгуулсан 6 үйл ажиллагаанд 284 хүүхэд хамруулсан. Хүүхдийн оролцооны байгууллагын 3 төслийг дэмжиж 5,900,000 төгрөгийн санхүүжилтийг олгосон | Оролцооны байгууллагын 90%-г хувийг сургалт, арга зүйгээр хангаж 8-аас доошгүй оролцооны байгууллагыг дэмжиж байр танхимаар хангана | 5.0 сая/ут/ | Оролцооны байгууллагын 90%-г хувийг сургалт, арга зүйгээр хангаж 8-аас доошгүй оролцооны байгууллагыг дэмжиж байр танхимаар хангана | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | | Хүүхдүүд |
| | 6.5 Хүүхдэд байгаль орчноо хайрлах, үндэсний өв уламжлал, соёл, ёс заншлаа мэдэх, хүндэтгэх, | 6.5.1 "Бидний соёлын өв " олон талт арга хэмжээг зохион байгуулна | Зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдсан хүний тоо | Бидний соёлын өв 5 арга хэмжээ зохион байгуулж 400 иргэд хамрагдсан | 8 төрлийн арга хэмжээ зохион байгуулж 600 иргэн хамруулна | 1.0 сая /ут/ | 10 төрлийн арга хэмжээ зохион байгуулж 800 иргэн хамруулна | Батлагдсан төсвийн хүрээнд | СУАЖЗГ | Номын сан | Иргэд |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | суралцахад чиглэсэн үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн музей, номын сан, хэвлэл мэдээлэл, соёл, урлагийн байгууллагуудаар дамжуулах хэрэгжүүлэх | 6.5.2 Хүүхдэд байгаль орчноо хайрлах, үндэсний өв уламжлал, соёл, ёс заншлаа мэдэх, хүндэтгэх, суралцахад чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах | Хамрагдсан хүүхдийн тоо, зохион байгуулсан ажлын тоо | Хүүхэд, залуучуудад соёлын өв, уламжлалт байгаль хамгаалах арга ухааны мэдлэг мэдээллийг 427 хүүхдэд сурталчлан ажилласан | Соёлын өв, уламжлалт ёс заншлыг түгээн дэлгэрүүлэх ажлыг 5 удаа зохион байгуулж 500-аас багагүй хүүхдийг хамруулна | | Соёлын өв, уламжлалт ёс заншлыг түгээн дэлгэрүүлэх ажлыг 7 удаа зохион байгуулж 800-аас багагүй хүүхдийг хамруулна | Батлагдсан төсвийн хүрээнд | СУАЖЗГ | Музей | Хүүхдүүд |
| | 6.6 Хүүхдийн тоглоомын талбай, чөлөөт цагийн төв байгуулах, тохижуулах, засварлах талаар санаачилга гаргаж байгаа иргэн, байгууллагыг дэмжих, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дэх заалтыг хэрэгжилтийг хангуулахад орон нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах | 6.6.1 Хүүхдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх хөдөлмөр зуслангийн үйл ажиллагааг зохион байгуулна | Хүүхдийн хөдөлмөр, өв соёл зуслангийн хөгжлийн хувилбарт үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо | 3 төрлийн зусланд 351 хүүхэд хамруулсан | 100-аас доошгүй хүүхэд хамруулна | 8.0 сая/онт/ 10.0 сая/ут/ | 120-иос доошгүй хүүхэд хамруулна | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | Сумдын ЗД | Хүүхдүүд |
| | | 6.6.2 Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дэх заалтыг хэрэгжилтийг хангуулахад орон нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах санал хүргүүлэх | Хуулийн заалтыг сурталчилж, хамтран ажилласан байгууллагын тоо | **** | 10-аас доошгүй ААН, байгууллагад санал хүргүүлж, хууль сурталчилна | 2.0 сая /ут/ | **** | | ХГБХХГ | ТГ | ААН |
| | 6.7 Хүүхдэд чиглэсэн хөгжлийн хувилбарт үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, чанар, хүртээмжийг сайжруулах, материаллаг баазыг бэхжүүлэх, хичээлээс гадуурх сонгон, секц, дугуйлангийн хүртээмж, үнэ төлбөрийн байдалд үнэлгээ хийх | 6.7.1 Хичээлээс гадуурх сонгон, секц, дугуйлангийн хүртээмжийг нэмэгдүлж, үнэ төлбөрийн байдалд үнэлгээ хийх | Нэмэгдүүлсэн үйлчилгээний нэр төрөл, үнэ төлбөрийн байдалд үнэлгээ хийсэн эсэх | **** | Үйлчилгээний нэр төрлийг 3-аар нэмэгдүүлнэ | | Хичээлээс гадуурх сонгон, секц, дугуйлангийн хүртээмж, үнэ төлбөрийн байдалд 1 удаа үнэлгээ хийнэ | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | БГ | Дугуйлан секцийн багш нар |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 6.8 Хүүхдийн дунд явагдах хөгжлийн арга хэмжээнд хүүхдийн жигд оролцоог хангах, оюун ухаан, урлаг, спортын олон төрлийн уралдаан, тэмцээн зохион байгуулах | 6.8.1 Хүүхдийн дунд оюун ухаан, урлаг, спортын олон төрлийн уралдаан, тэмцээн зохион байгуулна | Зохион байгуулсан тэмцээн уралдааны тоо, хамрагдсан хүүхдийн тоо | 8 төрлийн уралдаан, тэмцээнд 801 хүүхэд хамрагдсан | 6-аас доошгүй уралдаан тэмцээн зохион байгуулж 1000-с доошгүй хүүхэд хамруулна. | 30.0 сая /онт/ 15.0 сая/ут/ | 8-аас доошгүй уралдаан тэмцээн зохион байгуулж 1100-с доошгүй хүүхэд хамруулна. | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | БГ,СУАЖ ЗГ | Хүүхдүүд |
| | 6.9 Урлаг, спортын чиглэлээр улс, олон улс, тив, дэлхийн чанартай уралдаан, тэмцээнд оролцох болзол хангасан, хүүхдийн санаачилсан шинэ бүтээлийг дэмжих, урамшуулах, | 6.9.1 Урлаг, спортын чиглэлээр улс, олон улс, тив, дэлхийн чанартай уралдаан, тэмцээнд оролцох болзол хангасан болон хүүхдийн санаачилсан шинэ бүтээлийг дэмжиж урамшуулна | Дэмжлэг авсан хүүхдийн тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ | Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон 1 хүүхдэд 500,00 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн | 5-аас доошгүй хүүхдийг дэмжиж урамшуулна | 12.0 сая/онт/ | 5-аас доошгүй хүүхдийг дэмжиж урамшуулна | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | ЕБС Сумдын ЗД | Хүүхдүүд |
| | 6.10 Хүүхдийн нийгэм, оюун санаа, ёс суртахуун, биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийг дэмжсэн контентийг дэмжих, хүүхдэд зориулсан мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүргэх, | 6.10.1 Хүүхэд, гэр бүлд зориулсан контентыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүргэнэ. | Хүүхэд, гэр бүлд зориулан бүтээсэн контентын тоогоор, хандалтын тоогоор | Хүүхэдү, гэр бүлд зориулсан 10 контент бүтээж 14536 иргэдийн хандалт авсан | Хүүхэд, гэр бүлд зориулсан 10-аас доошгүй контент бүтээж 15000-аас дээш иргэдийн хандалт авна | 2.5 сая /ут/ | Хүүхэд, гэр бүлд зориулсан 10-аас доошгүй контент бүтээж 18000-аас дээш иргэдийн хандалт авна | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | Сумдын ЗД | Иргэд |
| **ЗОРИЛТ 7. ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗАМААР ХҮҮХДИЙН СЭРГИЙЛЖ БОЛОХ ӨВЧЛӨЛ, ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛНА** | | | | | | | | | | | |
| 7 | 7.1 Товлолт болон сайн дурын дархлаажуулалтад хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх | 7.1.1 Товлолт болон сайн дурын дархлаажуулалтад хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ | Товлолт болон сайн дурын дархлаажуулалтад хүүхдийн хамрагдалтын хувь | 94.30% | 96.50% | Батлагдсан төсвийн хүрээнд | 98.30% | Батлагдсан төсвийн хүрээнд | ЭМГ | ЭМБ-ууд, | Төрийн ба ТББ |
| | 7.2 Хүүхэд бүрийг бодисын солилцооны эмгэг, хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн эрт илрүүлэг, үзлэг оношилгоонд | 7.2.1 Хүүхэд бүрийг товлолт насны эрт илрүүлэг үзлэгт хамрагдуулна | Зорилтот насны хүүхдийн хамрагдалтын хувь | 70% | 75% | Батлагдсан төсвийн хүрээнд | 80% | Батлагдсан төсвийн хүрээнд | ЭМГ | ЭМБ-ууд, | Хүүхдүүд |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтмол хугацаанд хамруулах | | | | | | | | | | |
| | 7.3 Алслагдсан болон орлого багатай өрхийн хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах арга хэмжээ авч, нэн шаардлагатай амин дэмээр хангах, амин дэм түгээх явцад хоол тэжээлийн зөвлөгөө өгөх ажлыг хавсран явуулах | 7.3.1 Алслагдсан болон орлого багатай өрхийн хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах арга хэмжээ авч, нэн шаардлагатай амин дэмээр хангах, амин дэм түгээх явцад хоол тэжээлийн зөвлөгөө өгөх ажлыг хавсран явуулна | Зорилтот бүлгийн хүүхдүүдийг хамруулсан хувь | 40% | 50% | Батлагдсан төсвийн хүрээнд | 60% | Батлагдсан төсвийн хүрээнд | ЭМГ | ЭМЯ, НҮБХС, ЭМБ-ууд, | Төрийн ба ТББ |
| | 7.4 Хүүхдийн шүдний цоорол, өвчлөлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлж, хүүхдийн шүдний эрүүл мэндийн мэдээлэл, сургалтыг өргөжүүлэх | 7.4.1 Хүүхдийн шүдний цоорол, өвчлөлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлж, хүүхдийн шүдний эрүүл мэндийн мэдээлэл, сургалтыг өргөжүүлнэ | Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүүхдийн тоо | 2560 | 3800 | Батлагдсан төсвийн хүрээнд | 4280 | Батлагдсан төсвийн хүрээнд | ЭМГ | ЭМЯ, ЭМБ-ууд, | Төрийн ба ТББ |
| | 7.5. Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол, үдийн цай хөтөлбөр, хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд хяналт тавих ажлыг эцэг, эхийн оролцоотой зохион байгуулах | 7.5.1 Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол, үдийн цай хөтөлбөр, хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд хяналт тавих ажлыг эцэг, эхийн оролцоотой зохион байгуулна | Цэцэрлэг, сургуулиудын хамрагдалтын хувь | 30% | 40% | | 50% | | ЭМГ | БСУГ | Цэцэрлэг, ЕБС |
| | 7.6 Хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүнсний бүтээгдэхүүний худалдаа, | 7.6.1 Хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүнсний бүтээгдэхүүний | Хэрэгжүүлсэн хүүхдийн байгууллагын хувь | 50% | 60% | | 70% | | ЭМГ | ХХААГ, БСУГ | Цэцэрлэг, ЕБС |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **үйлчилгээг сургууль, цэцэрлэгийн орчинд хориглох** | **худалдаа, үйлчилгээг сургууль, цэцэрлэгийн орчинд хориглоно** | | | | | | | | | |
| | **7.7 Өсвөр үеийнхэнд ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл амьдралын хэв маягт төлөвшүүлэх** | **7.7.1 Өсвөр үеийнхэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулна.** Эрүүл мэндийн боловсролыг дэмжинэ | **Өсвөр үеийхэнд ээлтэй ажилсан эрүүл мэндийн байгууллагын тоо** | 7 | 9 | **Батлагдсан төсвийн хүрээнд** | 11 | **Батлагдсан төсвийн хүрээнд** | **ЭМГ** | **АНЭ. ЭМБ-ууд.БС.ГБХХХГ.ЦГ.** | **Хүүхдүүд** |
| | **7.8 Өсвөр насныхны нөхөн үржихүйн болон сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхыг аймаг, сумын түвшинд сайжруулах** | **7.8.1 Өсвөр насныхны нөхөн үржихүйн болон сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхыг аймаг, сумын түвшинд сайжруулна** | **Өсвөр насны хүүхдүүдийн тусламж үйлчилгээнд хамрагдсан хувь** | 40% | 50% | **Батлагдсан төсвийн хүрээнд** | 60% | **Батлагдсан төсвийн хүрээнд** | **ЭМГ** | **ЭМБ-ууд** | **ЕБС** |
| | **7.9 Сургууль, цэцэрлэг, хүүхдийн эмнэлэг болон хүүхдийн сургалт, үйлчилгээний байгууллагын эрүүл ахуйн стандартын шаардлагыг тогтоож мөрдүүлэх** | **7.9.1 Сургууль, цэцэрлэг болон хүүхдийн сургалт, үйлчилгээний байгууллагын эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийх** | **Хяналт шалгалтын тоо, хамруулсан байгууллага, ахуй нэгжийн тоо** | 40% | 50% | **Батлагдсан төсвийн хүрээнд** | 70% | **Батлагдсан төсвийн хүрээнд** | **ЭМГ** | **БСШУГ** | **ЕБС, СӨБ,** |
| | **ЗОРИЛТ 8. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГААГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗАМААР ХҮЧИРХИЙЛЛИЙГ БУУРУУЛНА** | | | | | | | | | | |
| 8 | **8.1.1 Гэр бүлийн хүчирхийллийн суурь судалгааг тодорхой давтамжтайгаар хийж, судалгаанд суурилсан төлөвлөлтийг хийх,** | **8.1 Гэр бүлийн хүчирхийллийн суурь судалгааг тодорхой давтамжтайгаар хийнэ** | **Судалгаа хийгдсэн эсэх** | **** | **Гэр бүлийн хүчирхийллийн 1 удаагийн суурь судалгаа хийнэ** | 35.0 сая /ГХУСАЗСЗ/ | **** | | **АИТХ** | **ХГБХХГ** | **Иргэд** |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 8.2 Гэр бүлийн харилцаанд жендерийн тэгш байдлыг хангахад чиглэсэн мэдээлэл, сургалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх, | 8.2.1 Гэр бүлийн харилцаанд жендерийн тэгш байдлыг хангахад чиглэсэн нөлөөллийн ажил зохион байгуулна | Хэрэгжүүлсэн арга хэмжээ, хамрагдсан хүний тоо | 2 нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, 2500 хүн хамруулсан | 5 нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, 5000 хүн хамруулсан байна | 4.0 сая /ут/ | 5 нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, 5000 хүн хамруулсан байна | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | Сумдын ЗД | Иргэд |
| | 8.3 Хохирогч болон хүчирхийлэл үйлдэгчид сэтгэц заслын үйлчилгээг үр дүнтэй хүргэх боломжийг бүрдүүлэх ба ялангуяа эрэгтэйчүүдийн зан үйл, сэтгэл зүйн онцлогт тохирсон модуль сургалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх | 8.3.1 Эрэгтэйчүүдийн зан үйл, сэтгэл зүйн онцлогт тохирсон модуль сургалт зохион байгуулах | Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан иргэдийн хувь | 2 сургалт зохион байгуулж 30 хүн хамруулсан | **** | | Суурь судалгаагаар илэрсэн гэр бүлийн хүчирхийлэлтэй өрхийн 40%-д үйлчилгээ, архинд хамааралтай иргэдийн 20%-г зан үйлд нөлөөлөх сургалтад хамруулна | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | ЦГ, Сумдын ЗД | Иргэд |
| | 8.4 Эмэгтэйчүүд, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүдийг хүчирхийллийн эрсдэлт хүчин зүйлээс өөрийгөө хамгаалах боломжийг нэмэгдүүлж, гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх, хяналтын тогтолцоог бүхий л түвшинд сайжруулах | 8.4.1 "Хөршийн холбоо" байгуулах | Хөршийн холбоо байгуулсан багийн тоогоор | | | | Хэрлэн сумын 3,4 дүгээрт багт "Хөршийн холбоо" байгуулна | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | Сумдын ЗД | Иргэд |
| | 8.5 Нэг цэгийн үйлчилгээний төвийг стандартын дагуу ажиллах нөхцөл боломжоор хангах | 8.5.1 Нэг цэгийн үйлчилгээний төвийг стандартын дагуу ажиллах нөхцөл боломжоор хангана | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ | Орон нутгийн төсөвт 50 сая төгрөг батлуулсан | Орон нутгийн төсвөөс 50.0 сая төгрөг батлуулна | 50.0 сая /онт/ | Орон нутгийн төсвөөс 50.0 сая төгрөг батлуулна | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | АЗДТГ | |
| **ЗОРИЛТ 9. ЗАЛУУ ГЭР БҮЛИЙГ ДЭМЖИХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ ГЭР БҮЛ САЛАЛТЫГ БУУРУУЛНА** | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 9.1 Залуу эцэг, эхчүүдэд зориулан хүүхдээ эрүүл өсгөн бойжуулах, хөгжлийг нь дэмжих, анхны жилүүдийн хямралыг даван туулах, ойлголцох, зөрчлийг шийдвэрлэхэд туслах сургалт зөвлөгөөнд зайлшгүй хамрагддаг нөхцөлийг бүрдүүлэх | 9.1.1 Залуу гэр бүлийг гэрлэлтийн гэрчилгээ авахын өмнөх сургалтад хамруулна | Гэрлэлтийн гэрчилгээ авахын өмнө сургалтад хамрагдсан хосын тоо | **** | Шинэ боловсруулсан арга зүйг Залуу хос, шинэ гэрлэгсдийн 20-иос дээш хувьд хэрэгжүүлнэ | 5.0 сая/ут/ | Шинэ боловсруулсан арга зүйг зорилтот бүлгийн 30-аас дээш хувьд хэрэгжүүлнэ | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | АЗДТГ, УБХ | Иргэд |
| | 9.2 Залуу гэр бүлийг хөнгөлөлттэй нөхцөлөөр байр сууцтай болох асуудлыг ажил олгогчид болон аж ахуйн нэгжүүдтэй хамтран шийдвэрлэх боломжийг нэмэгдүүлэх | 9.2.1 Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааны аймгийн хөтөлбөрт Залуу гэр бүлийг орон сууцжуулах заалт тусгана | Заалт тусгасан эсэх | **** | Заалт тусгуулсан байна. | | ***** | | ХГБХХГ | АЗДТГ | |
| | | 9.2.2 Залуу гэр бүлийг хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцжуулах хөтөлбөрт хамруулна | Хөнгөлөлттэй нөхцөлөөр гэр, орон байрны дэмжлэг авсан залуу гэр бүлийн тоо | **** | Орон сууцжуулах хөтөлбөрт хөнгөлөлттэй нөхцөлөөр хамрагдсан иргэдийн 10% нь залуу гэр бүл байна | | Орон сууцжуулах хөтөлбөрт хөнгөлөлттэй нөхцөлөөр хамрагдсан иргэдийн 10% нь залуу гэр бүл байна | | "Хэнтий орон сууц" ОНӨААТҮГ | ХГБХХГ, АЗДТГ | Иргэд |
| | 9.3 Залуучуудын ажлын байр нэмэгдүүлж гэр бүлийн санхүүгийн чадавхыг дээшлүүлэх, эдийн засгийн чадавхгүй залуу гэр бүлд дэмжлэг үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх | 9.3.1 Орон нутагт бүтээн байгуулалт хийж байгаа ААН-үүдэд залуу гэр бүлийг ажлын байраар хангаж ажиллах чиглэл хүргүүлж, хяналт тавих, ажлын байраар хангагдсан залуучуудын тоог нэмэгдүүлнэ | Ажлын байраар хангагдсан залуучуудын тоо | Улирлын чанартай ажлын байраар 158 залуу хангагдсан | Улирлын чанартай ажлын байраар 170 залууг хангана | | Улирлын чанартай ажлын байраар 180 залууг хангана | | ХХҮГазар | Аймгийн ХЭЗөвлөл | Иргэд |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛТ 10. ХӨДӨӨГИЙН ГЭР БҮЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХҮРТЭХ БОЛОМЖИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ** | | | | | | | | | | | |
| 10 | 10.1 Хөдөөгийн гэр бүлд хөгжлийн үйлчилгээг цогцоор хүргэх боломжийг нэмэгдүүлэх, эрүүл амьдралын дадалд суралцуулах | 10.1.1 Хөдөөгийн гэр бүлд явуулын үйлчилгээ үзүүлнэ | Явуулын үйлчилгээнд хамрагдсан өрхийн тоо | **** | 1 сумын 2 доошгүй багийн 100-аас доошгүй өрхөд явуулын үйлчилгээ үзүүлнэ | 8.0 сая/ут/ | 1 сумын 2 доошгүй багийн 120-иос доошгүй өрхөд явуулын үйлчилгээ үзүүлнэ | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | Сумдын ЗД | Иргэд |
| | 10.2 Гэр бүлийг хөгжүүлэх, тэдний шаардлагатай мэдээллээр хангах, олон нийтийн ажиллагаанд оролцох боломжийг бүрдүүлэх, үйлчилгээг хүргэх оновчтой арга, хэлбэрийг бий болгох | 10.2.1 "Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг хэрхэн танин мэдэх, мэдээлэх" талаарх сургалт зохион байгуулж Хүүхэд, Гэр бүлийн Нийгмийн ажилтан, багийн Засаг дарга нарыг хамруулна | Сургалтад хамрагдсан Хүүхэд, Гэр бүлийн нийгмийн ажилтны хувь | Хамтарсан багийн бүсчилсэн уулзалт сургалт зохион байгуулж 144 гишүүнийг хамруулсан | Хүүхэд, гэр бүлийн Нийгмийн ажилтны 85 хувийг сургалтад хамруулна | 5.0 сая/ут/ | Хүүхэд, гэр бүлийн Нийгмийн ажилтны 90 хувийг сургалтад хамруулна | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | Сумдын ЗД | Хамтарсан багийн гишүүд |
| | | 10.2.2 "Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг хэрхэн танин мэдэх, мэдээлэх" талаар сургалт зохион байгуулж иргэдийг хамруулна | Сургалтад хамрагдсан иргэдийн тоо | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалтад 1300 иргэн хамрагдсан | 1500-аас доошгүй иргэдийг сургалтад хамруулна | 5.0 сая/ут/ | 1500-аас доошгүй иргэдийг сургалтад хамруулна | Батлагдсан төсвийн хүрээнд | ХГБХХГ | Сумдын ЗД | Иргэд |